



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 04 он дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар ХЭГ/759

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт⁸ хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000225003499

ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг бодлогын баримт бичигт Монгол Улсын Засгийн газар хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх талаар зорилт, арга хэмжээг тусгасан.

Үүний дагуу Засгийн газраас хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогыг дараах гурван чиглэлд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж эхлээд байна. Үүнд:

- I. Хувийн эрх зүйн хууль тогтоомжийг боловсронгуй болгох;
- II. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийн тайлбарыг сайжруулах, иргэний хэргийн шүүхийн шүүгч, хуульч, судлаачдыг үе шаттай мэргэшүүлэх, хувийн эрх зүйн мэргэшсэн хуульчдыг бэлтгэх, хуулийн сургуулийн сургалт, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох;
- III. Олон улсын хувийн эрх зүйн асуудлаар олон улсын байгууллага, бусад улстай хамтын ажиллагааг сайжруулах.

Нэг. Хууль тогтоомжийн шинэтгэлийн бодлогын хүрээнд:

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хийгдсэн эрх зүйн хамгийн том шинэчлэл нь 2002 оны Иргэний хууль гэж хэлж болно. Иргэний хууль батлагдсантай холбогдуулан тухайн цаг үед үйлчилж байсан хуулиудыг уялдуулан шинэчилсэн боловч зарим хуулиудыг тус хуулийн суурь зохицуулалт, үзэл баримтлалд өнөөдрийг хүртэл нийцүүлж чадаагүй байна. Мөн эдийн засаг, бизнесийн хөгжил, технологийн үсрэнгүй дэвшил, нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

Монгол Улсын Засгийн газар дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд Оюуны өмчийн болон Цахимын багц хуулийг санаачлан боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулсан бөгөөд цаашид дараах хуулийг боловсронгуй болгох замаар хувийн эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэхээр ажиллаж байна.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

➢ Гадаадын зарим улс орнууд КОВИД-19 цар тахлын улмаас түр хугацаанд хэрэгжих болон шаардлагатай бусад эрх зүйн зохицуулалтыг бий болгоод байгаа¹ бөгөөд тухайлбал, цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгжид дампуурлын хэрэг үүсгэх мораториумын хугацааг сунгахаар заасан байна. Түүнчлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Нидерланд, Унгар зэрэг улсуудад төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аж ахуйн нэгжид бүтцийн өөрчлөлтийн ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлээд байна.

¹ EY Global Legal Commercial Terms Handbook 2020

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс авсан мэдээллээр Монгол Улсын шүүхээр 2004-2021 он буюу 18 жилийн хугацаанд нийт 268 дампуурлын хэрэг хянан шийдвэрлэгдсэнээс КОВИД-19 цар тахал гарснаас хойш буюу 2020 онд 15, 2021 онд 5 хэрэг шийдвэрлэгдсэн тоо баримт байна.

Иймд Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна. Хуулийн төслөөр төлбөрийн чадваргүйдлийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлж, төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх бүтцийн өөрчлөлтийн ажиллагаа буюу хуулийн этгээдийн үйл ажиллагааг сэргээх, дампуурахаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой ажиллагааны талаар шинэлэг зохицуулалтыг тусгаад байна. Мөн төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгах, хуулийн этгээд болон иргэн, хөрөнгө оруулагчийн хооронд өрийн сүлжээ, дарамт үүсэх явдлыг хязгаарлах, санхүү, зах зээлийн харилцааны ил тод байдлыг хангах, бизнес эрхлэлтийг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

➤ Барьцаалан зээлдүүлэх газар, иргэнээс олгох зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгож, мөнгө хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох, мөн тэдгээрийг Иргэний хуульд заасан нэг удаагийн шинжтэй иргэд хоорондын зээлийн гэрээнээс ялгах business-to-consumer болон consumer-to-consumer зарчимд үндэслэн Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Тус хуулийн төслөөр зээл авах иргэдийн эрх ашиг, эд хөрөнгийг хамгаалахаас гадна бичил санхүүгийн хэрэглэгч буюу зээлдүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлж, эдгээр үйл ажиллагаа эрхлэгчийн нэгдсэн бүртгэл бий болсноор мөнгөний эргэлт нь тодорхой болж, татвар шударгаар төлөгдөх нөхцөлийг бий болгоно.

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа хуулийн төслүүд

➤ Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэж байна. Хуулийн төсөлд төр болон орон нутаг зөвхөн тооцоо, судалгааны үндсэн дээр тодорхой салбарт эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх, эсхүл нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор компани үүсгэн байгуулах боломжтой байх, хувийн хэвшилтэй тэгш нөхцөл, ижил дүрмээр аж ахуй эрхлэх замаар баялгийг бий болгох, баялгийг оновчтойгоор дахин хуваарилах тогтолцоог бий болгох суурь нөхцөлийг бүрдүүлж, хувийн хэвшлийн гүйцэтгэх боломжтой, төрийн оролцоо шаардлагагүй, зах зээлийн зарчмаар хөгжих боломжтой тодорхой салбаруудад төр хутгалдан орж өрсөлдөөнийг хязгаарлах, алдагдал учруулах бизнесийн эрсдэлээс зайлсхийх боломжийг олгоно.

Түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагын багийг мэргэжлийн, чадварлаг, хараат бус, хөндлөнгийн хяналттай гишүүдээр бүрдүүлэх, сонгон шалгаруулах, тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны тайлагнал, ил тод байдлыг хангах механизмыг бүрдүүлэхэд чиглэж байна.

➤ Шүүхийн үйлчилгээг иргэд, арилжаа эрхлэгчдэд чирэгдэлгүйгээр цаг хугацааны хувьд түргэн шуурхай хүргэх, мөнгө, санхүүгийн хувьд хэмнэлттэй байх, нөгөөтэйгүүр шүүх талаас иргэдийн хэрэг, маргааныг төвөггүй, түргэн шуурхай шийдвэрлэдэг байх зарчмыг хангах, шүүхийн ачааллыг бууруулах, ингэснээр иргэд болон арилжаа эрхлэгчдийн хэрэг, маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх процессыг хөнгөвчлөх, шат дамжлагыг багасгах, бага үнийн дүнтэй хэргийг шийдвэрлэх онцлог зохицуулалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган боловсруулж байна.

Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” судалгааны² статистикаас үзвэл манай улсын хувьд гэрээнээс үүдэлтэй маргааныг шийдвэрлэх хугацаа, маргаан шийдвэрлэх зардал, шүүхийн үйл ажиллагааны чанарын индексээр (quality of judicial processes index) үнэлгээ хийж гаргадаг бөгөөд 2020 оны байдлаар 15,666,406 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагатай иргэний маргааныг шийдвэрлэхэд дунджаар 374 хоног, 22.9 хувийн зардалтайгаар шийдвэрлэдэг байна. Тус судалгааны шүүхийн үйл ажиллагааны чанарын индексийн үзүүлэлтээр 18 онооноос 5.5 оноо авснаас үзэхэд гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлийн реформууд, тэр дундаа бизнесийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх шүүхийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах ажлыг яаралтай эхлүүлэх шаардлагатай байна. Мөн шүүхийн үйл ажиллагааны чанарын индексийн үзүүлэлтэд хамаарах асуултуудад оноо авч чадаагүй байна.

Түүнчлэн бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн үнийн дүнг улс орнууд харилцан адилгүй тогтоодог бөгөөд манай улсын хувьд бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг 10 сая хүртэлх төгрөг гэж үзвэл 2017-2019 оны хугацаанд Иргэний хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхүүдээр хянан шийдвэрлэгдсэн бага үнийн дүнтэй хэрэг маргааны эзлэх хувийг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн түвшинд судалж үзэхэд шат шатны шүүхийн түвшинд харьцангуй өндөр байна. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхийн тухайд 3 хэрэг тутмын 1 нь буюу 33 хувь, давж заалдах шатны шүүхийн тухайд 4 хэрэг тутмын 1 нь буюу 24.7 хувь байгаа бол хяналтын шатны шүүхийн нийт хэргийн 23.8 хувийг эзэлж байна.

Иймд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хугацаа (жишээ нь зээлийн гэрээний маргааныг шийдвэрлэж байгаа дундаж хугацаа 6.2 жил байгаа бол хамгийн их хугацаа нь бүх шатны шүүхээр орсон болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас гүйцэтгэсэн хугацааг оруулаад 16.6 жил байна), улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, иргэн болон захиргааны хэргийн шүүхийн хэрэг, маргааны харьяаллын давхардлыг арилгах, олон улсын чиг хандлагад нийцүүлэн цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох эрх зүйн орчинг бүрдүүлэх юм.

➤ Иргэний, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт хангалтгүй, ялангуяа албадлагын арга хэмжээ болон хөрөнгийн үнэлгээний гомдлыг шүүхээс хянан шийдвэрлэж байгаа хугацаанаас хамаарч ажиллагаа удаашрах, төлбөрөөс зайлсхийх зорилгоор шат шатны шүүхэд төлбөр төлөгч гомдол, нэхэмжлэл гаргаж байна.

Мөн жил бүр ойролцоогоор 1 их наяд төгрөгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх баримт бичиг биелэгддэггүй байна. 2022 оны 2 дугаар сарын байдлаар

² https://www.doingbusiness.org/en/data/exploreeconomies/mongolia#DB_ri

биелүүлбэл зохих 1.8 их наяд төгрөгийн 22842 гүйцэтгэх хуудас биелүүлэхээс 3180 гүйцэтгэх хуудасны 80.1 тэрбум төгрөгийг биелүүлж, 19662 гүйцэтгэх хуудас биелэгдээгүй үлджээ.

Иймд иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг шүүх эрх мэдлийн байгууллагад шилжүүлэн хэрэгжүүлэх, шийдвэр гүйцэтгэлийн урамшуулал тооцох тогтолцоог сэргээх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг сайжруулах, түргэсгэх, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарцаагүй биелэгддэг нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулж байна.

➤ Гэр бүлийн эрх зүйд гэр бүлийн хөрөнгийн эрх буюу гэрлэгчдийн дундаа хэсгээр өмчлөх, эсхүл хамтран өмчлөх эд хөрөнгийн эрхийн зохицуулалтыг тодотгож нарийвчлах, түүнчлэн хүйс солиулах асуудал гэрлэлтэд ямар үр дагавар үүсгэх, тээгч эхээр хүүхэд тээлгэх, зохиомлоор үр суулгах болон гэр бүл, өв залгамжлалыг тодорхой болгох зорилгоор Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж байна.

➤ Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг дэмжих зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Хуулийн хүрээнд Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70 гаруй хувь нь зөвхөн уул уурхайн салбарт, 18 орчим хувь нь худалдаа, нийтийн хоолны салбарт хийгдэж, эдийн засаг ерөнхийдөө уул уурхайн салбараас хамааралтай байгаа нөхцөлийг харгалзан эдгээр салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтыг хамгаалж үлдэх, бусад салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтын баталгааг тогтоох, хөрөнгө оруулагчид олгох татварын болон татварын бус дэмжлэгийн талаарх зохицуулалтыг оновчтой байдлаар тусгах, хууль хоорондын уялдаа холбоог хангах, тодорхой бус зохицуулалтуудыг ойлгомжтой болгох юм.

Боловсруулалтын шатанд байгаа хуулийн төслүүд

➤ Монгол Улсад бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлсэн эсэх талаар Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” судалгааны³ статистикийг гол баримжаа болгож харвал 2010-2020 он хүртэлх 10 жилийн хугацаанд Монгол Улс 59.9 онооноос 67.8 оноо болж өссөн үзүүлэлттэй байгаа бол тус судалгааны нэг бүлэг шалгуур үзүүлэлт болох “гэрээний хэрэгжилтийг хангах” үзүүлэлтийн хувьд 2004-2013 онд 71.8, 2014-2015 онд 70.2, 2016-2018 онд 58.5, 2019-2020 онд 61.4 оноо болж, тогтмол буурсан үзүүлэлтэй гарсан байна.

Монгол Улсад худалдаа, арилжаатай холбоотой харилцааг Иргэний хууль болон тусгайлсан хуулиуд (Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай, Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Даатгалын тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Санхүүгийн түрээсийн тухай гэх мэт)-аар зохицуулж байгаа боловч аж ахуй эрхлэгч хоорондын харилцааг цогц байдлаар зохицуулсан эрх зүйн тогтолцоо байхгүй байна.

³ https://www.doingbusiness.org/en/data/exploreeconomies/mongolia#DB_ri

Өөрөөр хэлбэл Иргэний хуульд аж ахуй эрхлэгч болон хэрэглэгч хоорондын, эсхүл иргэд хоорондын харилцааг илүүтэйгээр зохицуулсан бөгөөд аж ахуй эрхлэгчдийн хооронд үүсэх бизнесийн онцлог харилцааг зохицуулсан хэм хэмжээг эдийн засгийн агуулгаар баяжуулж, тодруулах шаардлагатай байна. Зах зээлийн суурь хуулиудад уг харилцаанд оролцогчдын, ялангуяа бизнес эрхлэгчдийн чөлөөт байдал, эрх тэгш байдлыг хуулиар тогтоох нь чухал ач холбогдолтой юм.

Тиймээс ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдах үеэс эхлээд тухайн аж ахуй эрхлэгч дампуурах, эсхүл татан буугдах хүртэл худалдаа арилжаа эрхлэхэд нийтлэг хийгддэг үйл ажиллагааг зохицуулсан шинжтэй бие даасан Арилжааны хууль боловсруулах, эсхүл аж ахуй эрхлэгчдийн хооронд үүсэх бизнесийн онцлог харилцааг зохицуулсан нийтлэг зохицуулалтыг Иргэний хуульд оруулах замаар арилжааны үйл ажиллагааны хүрээнд үүсэх эрх зүйн харилцааг (B2B) зохицуулах нь зүйтэй байна. Ингэснээр бизнес эрхлэгчдийн ашгийн төлөө зорилгыг дэмжих, гэрээнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, үүссэн хэрэг маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх, бизнесийн ёс зүй, хариуцлагыг төлөвшүүлэх, бизнес эрхлэгчдийн ажил үүргийн хүрээнд тогтсон зан заншлын хэм хэмжээг хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

➤ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн гэрээний асуудлыг зохицуулах Хэрэглэгчийн гэрээний тухай хуулийн төслийг боловсруулж байна. Олон улсад хэрэглэгчийн гэрээний зохицуулалт, зайнаас гэрээ хийх, бүтээгдэхүүний хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээтэй шинэ зохицуулалт бий болжээ. Түүнчлэн гэрээний стандарт нөхцөлийг нийтэд санал болгодог салбарууд (харилцаа холбоо, банк, санхүү, шатахуун, боловсрол, сургалтын байгууллага гэх мэт)-д хэрэглэгчдийн эрх зөрчигдөх явдал түгээмэл байх тул стандарт нөхцөлтэй хэрэглэгчийн гэрээнээс үүдэлтэй маргааныг богино хугацаанд зардал багатайгаар шийдвэрлэх нэг арга зам болох олон тооны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, нэхэмжлэл гаргах асуудлыг (class action) эрх зүйгээр зохицуулж байна.

Арилжаа эрхлэгчээс үзүүлж байгаа нэг төрлийн ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний улмаас олон хэрэглэгч адил төрлийн нэхэмжлэл гаргах магадлалтай бол тэдгээрийг төлөөлөн нэг хэрэглэгч нэхэмжлэл гарган хохирлоо барагдуулах боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр тухайн компанитай маргах хүсэлтэй хэрэглэгч шүүхээр маргаанаа шийдвэрлүүлснээр бусад хэрэглэгч дахин нотлох шаардлагагүйгээр хохирлоо барагдуулах нөхцөл бүрдэх юм.

➤ Шүүхийн ачааллыг бууруулж, маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх боломжийг бий болгох, иргэдийн цаг хугацаа, хөрөнгийг хэмнэх зорилгоор Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж байна. Хуулийн төслүүдээр маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх боломжийг бататгаж, хуулийн хүрээ, маргааны төрлийг өргөжүүлэх, маргаан шийдвэрлэх ажиллагааны процессыг нарийвчлах, цахимжуулах зэрэг зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх юм.

➤ Хөрөнгө оруулагчдыг татах, бизнес эрхлэгчдийн эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Компанийн тухай хуулийг шинэчлэн боловсруулна. Хуулийн төслөөр хязгаарлагдмал хувьцаат компани болон хувьцаат компанийн эрх зүйн зохицуулалтыг ялгамжтай зохицуулах, гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх

эрх зүйн орчныг нарийвчлах, хязгаарлагдмал хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргалтад тулгамдаж байгаа асуудлыг зохицуулах, хувьцаат компанийн тухайд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, компанийг төлөөлөх эрх бүхий этгээдийн төрлийг нэмэх, төлөөлөн удирдах зөвлөл өөрсдийн үйл ажиллагааны тайланг танилцуулах зохицуулалтыг бий болгох, хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар хуралдуулах болон компани байгуулах, өөрчлөх, татан буулгах, бүртгэх асуудлыг цахимжуулах хэлбэрээр шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгоно.

➤ Мөн төлбөрт таавар, бооцоот тоглоом, хонжворт сугалаа, бооцоот морин уралдаан, казиногийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн төслийг багцаар нь боловсруулахаар ажиллаж байна.

Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт эрх бүхий байгууллагад ирдэг боловч казино, мөрийтэй тоглоом, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаа зэргийн хоорондын ялгаа, эдгээрт ямар тоглоом хамаарах, үйл ажиллагаандаа ямар дүрэм журмыг мөрдөх, юуг хориглох зэргийг тодорхойлсон хууль байхгүйн улмаас 2006 оноос хойш ийм төрлийн тусгай зөвшөөрлийг олгоогүй байна.

Харин сүүлийн жилүүдэд цахим орчинд казиногийн тоглоом, спортын болон бусад төрлийн бооцоот тоглоом эрхэлдэг гадаадын хуулийн этгээдийн үйл ажиллагаа Монгол Улсын иргэдийн дунд эрчээ авч байгаа нь зайлшгүй шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болж байна.

Тухайлбал, 2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд бооцоот тоглоомын вэбсайтад хандаж, бооцоо тавьдаг хэрэглэгчдийн тоо 100 мянга давсан бөгөөд үүнээс идэвхтэй хэрэглэгчдийн тоо 15000-20000 байна гэсэн албан бус судалгаа байна. Мөн тус албан бус судалгаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 20 гаруй агент буюу зуучлагч байна гэсэн бөгөөд эдгээр агентаар дамжин Монгол Улсаас гарч байгаа мөнгө нь нэг сард 10 тэрбум төгрөгт хүрээд байна гэсэн байна.

Иймд цахим орчин дахь хууль бус мөрийтэй тоглоомын үйл ажиллагаатай тэмцэх, нэгэнт эрчээ авсан бооцоот тоглоомын бизнесийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулах, олсон орлогодоо татвар төлдөг байх зэргийг нэн тэргүүнд зохицуулах шаардлагатай байна.

Түүнчлэн унаач хүүхдийн эрхийг зөрчихгүйгээр өв соёл, түүхэн уламжлалаа тээж үлдэх, соёл, уламжлалаараа жуулчдыг татах шаардлага байгаа бөгөөд хурдан морь эзэмшигч, уяачдад аль ч улиралд морио уралдуулах, Үндэсний баяр наадамд уралдуулж чаддаггүй морио уралдуулах бололцоог бий болгох, олон улсын жишигт нийцсэн морин тойруулга байгуулж, бооцоот морин уралдаан зохион байгуулах эрх зүйн орчныг бий болгох нь ач холбогдолтой гэж үзэж байгаа тул Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Казиногийн тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах бөгөөд казиногийн үйл ажиллагааг Засгийн газраас олгох цөөн тооны тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн чөлөөт бүсэд эрхлэхийг зөвшөөрөх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мөрдвөл зохих нөхцөлийг тодорхой тусгана.

Түүнчлэн казиногоос болж нийгэмд үүсэж болзошгүй сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх үүднээс Монгол Улсын иргэн болон насанд хүрээгүй хүнийг казиногийн тоглоом тоглуулахгүй, казиногийн байгууламжид нэвтрүүлэхгүй байхаар, харин аялал жуулчлалыг дэмжих, иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх газрын сонголтыг нэмэхэд эерэг нөлөө үзүүлэх казиногийн цогцолбор дахь (казиногийн байгууламжаас бусад хэсэг) үзвэр, үйлчилгээний газруудаар насанд хүрээгүй хүн, Монгол Улсын иргэн үйлчлүүлэхэд хязгаарлалтгүй байх зохицуулалтыг тусгахаар төлөвлөж байна.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар казиногийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан цөөн тооны хуулийн этгээдэд олгох эрх зүйн орчин бүрдэх бөгөөд ингэснээр аялал жуулчлалын томоохон цогцолбор бий болж, Монгол Улсын төсөвт төвлөрөх татварын орлого нэмэгдэн, аялал жуулчлалын салбар болон түүнийг дагасан худалдаа, үйлчилгээ хөгжиж, ажлын байр нэмэгдэн улс орны эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулна хэмээн үзэж байна.

Хоёр. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийн тайлбарыг сайжруулах, иргэний хэргийн шүүхийн шүүгч, хуульч, судлаачдыг үе шаттай мэргэшүүлэх, хувийн эрх зүйн мэргэшсэн хуульчдыг бэлтгэх, хуулийн сургуулийн сургалт, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр:

Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан дэвшилттэй зохицуулалтын нэг нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үүднээс Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбар, Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэхээр болсон.

Түүнчлэн шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг сургалт, судалгаа, мэдээллээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал бэлтгэх, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнг Улсын дээд шүүхийн дэргэд ажиллуулахаар хуульчилж, тус хүрээлэн байгуулагдан ажиллаж байна.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажилласнаар шүүгчийг мэргэшүүлэх хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох, Улсын дээд шүүх нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

Түүнчлэн батлагдсан хуулийг нэг мөр ойлгох, хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор Засгийн газраас боловсруулж байгаа Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хууль санаачлагчаас боловсруулсан тухайн хуулийн төслийн танилцуулгыг дэлгэрэнгүй байдлаар бичиж, хуулийн хувийн хэрэгт хадгалах зохицуулалтыг тусгаад байна.

Энэ нь хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтын талаар дэлгэрэнгүй тайлбар хийх, өөрчлөлт оруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, ухагдахууны агуулга, хуулийн төслөөр зохицуулж байгаа харилцаа, түүний зохицуулалтыг хэрхэн ойлгох талаарх мэдээллийг оруулах бөгөөд ингэснээр хууль санаачлагч ямар агуулгаар холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан талаар хууль хэрэглэх явцад ойлгомжгүй нөхцөл байдал үүсвэл танилцуулгад дурдсан тайлбарыг эх сурвалж болгон ашиглаж болох юм. Энэ нь хэрэг, маргааныг шүүх, арбитраар хянан шийдвэрлэж, холбогдох хуулийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэхэд чухал ач холбогдолтой байх болно.

Хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хууль тогтоомжийг боловсронгуй болгохоос гадна хувийн эрх зүйн харилцаанд үүссэн аливаа асуудлыг шүүгч, өмгөөлөгч, хуульч, судлаачид хуулийн үзэл санаа, зорилгод нийцүүлэн тайлбарлаж хэрэглэх замаар хэрэгжүүлнэ. Мөн шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хууль дээдлэх ёсыг хангаж, нийгмийн хэрэгцээ шаардлагыг мэдэрч, техникийн дэвшилд нийцүүлэн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Эдийн засаг, арилжаа, бизнесийн чиглэлээр шүүгч, хуульчдыг мэргэшүүлэх, бэлдэх асуудлыг “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр II”-ийн хүрээнд тусгаж, хувийн эрх зүйн чиглэлээрх боловсон хүчнийг үе шаттайгаар бэлтгэхээр төлөвлөж байна.

Тухайлбал, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд эрх зүйн бакалаврын сургалтын хөтөлбөрт суралцагч нь хууль зүйн мэргэжлийн боловсрол эзэмшиж төгсөхдөө хувийн эрх зүйн чиглэлийн хичээлийн багц цагийг хангасан байхаар боловсруулсан. Түүнчлэн, хувийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг хуульч, судлаачдад судалгааны тэтгэлэг олгодог хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх бодлогыг баримтална.

Гурав. Олон улсын хувийн эрх зүйн асуудлаар олон улсын байгууллага, бусад улстай хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр:

Олон улсын хувийн эрх зүйд хамаарах Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн явцын талаар нэгдсэн тайлан гаргаж, цаашид голчлон анхаарах салбар, гэрээ, конвенцыг тодорхойлох, үүнтэй уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллана.

Түүнчлэн бусад улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ нэмж байгуулах, олон улсын хувийн эрх зүйн чиглэлийн гэрээнд нэгдэн орох эсэх судалгааг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлж, хууль бол хязгаарлалт бус “боломж” гэдэг үзэл баримтлалыг бэхжүүлэхээр зорьж байгаа болно.

-----oOo-----